



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ” ТӨҮГ-ЫН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/26/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: С.Нацагдорж
Утас: 51-261885 Цахим хаяг: natsagdorjs@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Болор-Эрдэнэ
Утас: 51-261740 Цахим хаяг: bolor-erdened@audit.gov.mn
Гэрээт аудитор: О.Наранбат
Утас: 51-261740 Цахим хаяг: naranbato@audit.gov.mn

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

| | |
|--|----|
| 1. Аудитын санал дүгнэлт | 2 |
| 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан..... | 4 |
| 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан..... | 4 |
| 2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан | 5 |
| 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан | 6 |
| 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан | 7 |
| 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл | 8 |
| 3. Аудитын тайлан..... | 9 |
| 3.1 Ерөнхий зүйл..... | 9 |
| 3.2 Дотоод хяналт..... | 9 |
| 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал | 9 |
| 3.4 Материаллаг байдал | 10 |
| 4. Санхүүгийн тайлангийн тодруулга | 10 |
| 4.1 Байгууллагын үйл ажиллагаа..... | 10 |
| 4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин..... | 10 |
| 4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого | 12 |
| 5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал..... | 17 |
| 5.1 Шилэн дансны мэдээлэл..... | 17 |
| 6. Өмнөх аудитын зөвлөмжийн хэрэгжилт | 18 |
| 7. Дараагийн аудитаар анхаарах асуудал | 19 |
| 8. Аудитын илрүүлэлт | 19 |
| 8.1 Залруулсан алдаа | 19 |
| 8.2 Төлбөрийн акт..... | 20 |
| 8.3 Албан шаардлага | 20 |
| 8.4 Зөвлөмж..... | 21 |
| 9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл | 23 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ААНОАТ | Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| АТҮТ | Автотээврийн үндэсний төв |
| НББОУС | Нягтлан бодох бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| НӨАТ | Нэмэгдсэн өртгийн албан татвар |
| СТОУС | Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар |
| ТӨҮГ | Төрийн өмчит үйлдвэрийн газар |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

“АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ”
ТӨҮГ-ЫН ЗАХИРАЛ Б.ГҮРСОРОНЗОН
ТАНАА

2022.03.15 № 07/574

танай _____-ны № _____-т
Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

“Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудалд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулсан ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.

“Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын тайлант онд нийт 25,398.3 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 23,512.9 сая төгрөгийн зардал гарган, 1,885.4 сая төгрөгийн ашигтай байхаар төлөвлөсөн байна. Гүйцэтгэлээр 27,272.0 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, 19,872.5 сая төгрөгийг зарцуулж, 7,399.5 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай ажиллажээ.

Бусад асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Тайлант онд тус газар нь Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.3-д заасны дагуу худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 344.9 сая төгрөгөөр бууруулан шинэчлэн баталж, хэмнэж ажилласан байна.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тус газрын 2021 оны “Ажил үйлчилгээг хариуцуулан гүйцэтгүүлэх гэрээ”-нд 267 арга хэмжээ төлөвлөснөөс тухайн жилд хэрэгжих 251 арга хэмжээгээр үнэлж, 1 арга хэмжээний хэрэгжилтийг үнэлэх боломжгүй, бүрэн буюу 100 хувийн хэрэгжилттэй 121 арга хэмжээ, 90.0 хувийн хэрэгжилттэй 17 арга хэмжээ, 70 хувийн хэрэгжилттэй 89 арга хэмжээ, 50.0 хувийн хэрэгжилттэй 4 арга хэмжээ, 30.0 хувийн хэрэгжилттэй 19 арга хэмжээ байгаа ба гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн дундаж үнэлгээ 82.2 хувьтай, өмнөх оны үнэлгээнээс 3.4 хувиар буурсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | Балансын зүйл | 2020 оны 12-р сарын 31 | 2021 оны 12-р сарын 31 |
|---------------|---------------------------------------|--------------------------|--------------------------|
| 1 | ХӨРӨНГӨ | - | - |
| 1.1 | Эргэлтийн хөрөнгө | 5,146,304,817.51 | 12,071,303,895.02 |
| 1.1.01 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө | 1,814,904,317.03 | 9,880,402,417.43 |
| 1.1.02 | Дансны авлага | 2,560,080.00 | 18,816,200.00 |
| 1.1.03 | Татвар, НДШ-ийн авлага | 56,755,733.19 | 30,827.27 |
| 1.1.04 | Бусад авлага | 101,315,833.61 | 80,918,349.59 |
| 1.1.06 | Бараа материал | 2,033,329,611.68 | 1,967,496,453.83 |
| 1.1.07 | Урьдчилж төлсөн зардал/тооцоо | 1,137,439,242.00 | 123,639,646.90 |
| 1.1.11 | Эргэлтийн хөрөнгийн дүн | 5,146,304,817.51 | 12,071,303,895.02 |
| 1.2 | Эргэлтийн бус хөрөнгө | - | - |
| 1.2.01 | Үндсэн хөрөнгө | 32,215,814,864.79 | 32,377,765,701.89 |
| 1.2.02 | Биет бус хөрөнгө | 6,703,629,165.43 | 6,613,904,121.72 |
| 1.2.10 | Эргэлтийн бус хөрөнгийн дүн | 38,919,444,030.22 | 38,991,669,823.61 |
| 1.3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | 44,065,748,847.73 | 51,062,973,718.63 |
| 2.1 | Өр төлбөр | 6,779,085,209.92 | 6,618,842,686.73 |
| 2.1.1.01 | Дансны өглөг | 248,063,731.34 | 234,600,150.15 |
| 2.1.1.02 | Цалингийн өглөг | - | 39,663.54 |
| 2.1.1.03 | Татварын өр | 202,595,900.58 | 714,818,250.79 |
| 2.1.1.08 | Урьдчилж орсон орлого | 255,196,084.58 | 234,553,947.03 |
| 2.1.1.10 | Бусад богино хугацаат өр төлбөр | 51,119,000.00 | 51,119,000.00 |
| 2.1.1.13 | Богино хугацаат өр төлбөрийн дүн | 756,974,716.50 | 1,235,131,011.51 |
| 2.1.2.01 | Урт хугацаат зээл | 5,909,628,706.99 | 5,271,229,888.79 |
| 2.1.2.03 | Хойшлогдсон татварын өр | 112,481,786.43 | 112,481,786.43 |
| 2.1.2.06 | Урт хугацаат өр төлбөрийн дүн | 6,022,110,493.42 | 5,383,711,675.22 |
| 2.2 | Өр төлбөрийн нийт дүн | 6,779,085,209.92 | 6,618,842,686.73 |
| 2.3 | Эздийн өмч | 241,840,000.00 | 241,840,000.00 |
| 2.3.01 | Өмч: - төрийн | 241,840,000.00 | 241,840,000.00 |
| 2.3.02 | - хувийн | - | - |
| 2.3.06 | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | 2,329,176,065.75 | 3,159,212,904.41 |
| 2.3.08 | Эздийн өмчийн бусад хэсэг | 20,189,683,837.30 | 20,286,497,030.04 |
| 2.3.09 | Хуримтлагдсан ашиг | 14,525,963,734.76 | 20,756,581,097.45 |
| 2.3.09.1 | Тайлангийн үеийн ашиг | - | 6,449,619,642.95 |
| 2.3.09.2 | Өмнөх үеийн ашиг | 14,525,963,734.76 | 14,306,961,454.50 |
| 2.3.11 | Эздийн өмчийн дүн | 37,286,663,637.81 | 44,444,131,031.90 |
| 2.4 | ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН | 44,065,748,847.73 | 51,062,973,718.63 |

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | 2020 оны 12-р сарын 31 | 2021 оны 12-р сарын 31 |
|---------------|--|-------------------------|-------------------------|
| 1 | Борлуулалтын орлого (цэвэр) | 19,826,166,232.51 | 25,511,850,741.62 |
| 2 | Борлуулалтын өртөг | 18,688,352,364.07 | 19,099,921,680.21 |
| 3 | Нийт ашиг(алдагдал) | 1,137,813,868.44 | 6,411,929,061.41 |
| 4 | Түрээсийн орлого | 157,201,157.63 | 159,087,832.17 |
| 5 | Хүүгийн орлого | 55,315,517.03 | 31,591,446.10 |
| 7 | Зорчигч тээврийн орлого | 3,383,943,129.21 | 1,536,812,031.58 |
| 8 | Бусад орлого | 37,976,381.85 | 32,630,127.17 |
| 8.1 | Орлогын дүн | 3,634,436,185.72 | 1,760,121,437.02 |
| 09 | Борлуулалт, маркетингийн зардал | 180,381,411.23 | 16,979,952.24 |
| 10 | Ерөнхий ба удирдлагын зардал | 1,356,119,834.00 | 826,386,722.72 |
| 11 | Санхүүгийн зардал | - | - |
| 12 | Бусад зардал | 33,588,308.76 | 26,304,864.13 |
| 12.1 | Зардлын дүн | 1,570,089,553.99 | 869,671,539.09 |
| 13 | Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз) | (512,971,312.64) | 160,896,251.92 |
| 17 | Бусад ашиг (алдагдал) | (118,321,464.53) | (63,782,353.94) |
| 17.1 | Олз, гарзын дүн | (631,292,777.17) | 97,113,897.98 |
| 18 | Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал) | 2,570,867,723.00 | 7,399,492,857.32 |
| 19 | Орлогын татварын зардал | 374,017,287.02 | 949,873,214.37 |
| 20 | Татварын дараах ашиг (алдагдал) | 2,196,850,435.98 | 6,449,619,642.95 |
| 21 | Зогсоосон үйл аж-ны татварын дараах ашиг(алдагдал) | - | - |
| 22 | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | 2,196,850,435.98 | 6,449,619,642.95 |
| 23 | Бусад дэлгэрэнгүй орлого | - | - |
| 23.1 | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү | - | - |
| 23.2 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - |
| 23.3 | Бусад олз (гарз) | - | - |
| 24 | Орлогын нийт дүн | - | - |
| 25 | Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал) | - | - |

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| № | Үзүүлэлт | Өмч | Хөр-н дахин үнэлгээний нэмэгдэл | Эздийн өмчийн бусад хэсэг | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
|----|---|-----------------------|---------------------------------|---------------------------|--------------------------|--------------------------|
| 1 | 2019 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл | 241,840,000.00 | 2,335,778,666.90 | 19,727,929,649.72 | 13,181,136,613.71 | 35,486,684,930.33 |
| 2 | НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | - | - | - | (852,023,314.93) | (852,023,314.93) |
| 4 | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | - | - | - | 2,196,850,435.98 | 2,196,850,435.98 |
| 6 | Өмчид гарсан өөрчлөлт | - | - | 461,754,187.58 | - | 461,754,187.58 |
| 8 | Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | - | (6,602,601.15) | - | - | (6,602,601.15) |
| 9 | 2020 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл | 241,840,000.00 | 2,329,176,065.75 | 20,189,683,837.30 | 14,525,963,734.76 | 37,286,663,637.81 |
| 10 | НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | - | - | (9,061,807.26) | - | (9,061,807.26) |
| 12 | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | - | - | - | 6,449,619,642.95 | 6,449,619,642.95 |
| 14 | Өмчид гарсан өөрчлөлт | - | - | 105,875,000.00 | - | 105,875,000.00 |
| 15 | Зарласан ногдол ашиг | - | - | - | (219,002,280.26) | (219,002,280.26) |
| 16 | Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | - | 830,036,38.66 | - | - | 830,036,838.66 |
| 17 | 2021 оны 12 сарын 31-р үлдэгдэл | 241,840,000.00 | 3,159,212,904.41 | 20,286,497,030.04 | 20,756,581,097.45 | 44,444,131,031.90 |

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | 2020 оны 12-р сарын 31 | 2021 оны 12-р сарын 31 |
|---------------|--|-------------------------|-------------------------|
| 1 | Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | - | - |
| 1.1 | Мөнгөн орлогын дүн (+) | 27,313,547,276.40 | 32,051,117,963.56 |
| 1.1.1 | Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого | 25,353,697,169.44 | 29,850,336,457.72 |
| 1.1.3 | Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө | 297,000.00 | - |
| 1.1.6 | Бусад мөнгөн орлого | 1,959,553,106.96 | 2,200,781,505.84 |
| 1.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | 22,066,081,818.72 | 22,592,474,020.58 |
| 1.2.1 | Ажиллагчдад төлсөн | 11,884,563,982.21 | 11,768,379,826.60 |
| 1.2.2 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | 1,510,282,544.61 | 1,594,191,969.72 |
| 1.2.3 | Бараа материал худалдан авахад төлсөн | 212,570,668.50 | 272,189,309.00 |
| 1.2.4 | Ашиглалтын зардалд төлсөн | 1,619,069,064.82 | 1,428,463,431.51 |
| 1.2.5 | Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн | 290,623,377.85 | 340,335,178.59 |
| 1.2.6 | Хүүгийн төлбөрт төлсөн | 116,881,122.34 | - |
| 1.2.7 | Татварын байгууллагад төлсөн | 2,055,509,639.66 | 1,810,535,349.38 |
| 1.2.8 | Даатгалын төлбөрт төлсөн | 59,119,688.40 | 56,385,411.83 |
| 1.2.9 | Бусад мөнгөн зарлага | 4,317,461,730.33 | 5,321,993,543.95 |
| 1.3 | Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | 5,249,027,057.68 | 9,458,643,942.98 |
| 2 | Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | - | - |
| 2.1 | Мөнгөн орлогын дүн (+) | 55,315,517.03 | 45,741,446.10 |
| 2.1.1 | Үндсэн хөрөнгө борлуулсны орлого | - | 14,150,000.00 |
| 2.1.6 | Хүлээн авсан хүүгийн орлого | 55,315,517.03 | 31,591,446.10 |
| 2.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | 2,944,411,279.27 | 741,710,946.04 |
| 2.2.1 | Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 2,614,051,610.27 | 549,765,785.29 |
| 2.2.2 | Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 330,359,669.00 | 180,235,386.75 |
| 2.2.6 | Бусад | - | 11,709,774.00 |
| 2.3 | Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | (2,889,095,762.24) | (695,969,499.94) |
| 3 | Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | - | - |
| 3.1 | Мөнгөн орлогын дүн (+) | - | - |
| 3.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | 1,816,300,057.80 | 697,176,342.64 |
| 3.2.1 | Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө | 954,520,057.80 | 477,491,282.64 |
| 3.2.4 | Төлсөн ногдол ашиг | 861,780,000.00 | 219,685,060.00 |
| 3.3 | Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | (1,816,300,057.80) | (697,176,342.64) |
| 4 | Бүх цэвэр мөнгөн гүйлгээ | 543,631,237.64 | 8,065,498,100.40 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 1,272,834,679.39 | 1,814,904,317.03 |
| 6 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 1,814,904,317.03 | 9,880,402,417.43 |

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

| № | Үзүүлэлт | Хэмжих нэгж | 2020 оны гүйцэтгэл | 2021 оны | | Зөрүү | Хувь |
|-----------------------------|--------------------------------------|----------------------|---------------------|---------------------|---------------------|----------------------|--------------|
| | | | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| А. Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт | | | | | | | |
| Үүнээс: | Техникийн хяналт оношилгоо | тоо хэмжээ | 13,103,718.3 | 12,838,776.9 | 13,826,962.7 | (988,185.8) | 107.7 |
| | Зорчигч тээвэр | зорчигч, ачаа эргэлт | 7,655,641.3 | 8,046,150.6 | 5,099,124.2 | 2,947,026.4 | 63.4 |
| | Бусад | мян/төг | 2,701,242.9 | 4,513,410.0 | 8,345,885.2 | (3,832,475.2) | 184.9 |
| 2 | Нийт орлого | мян/төг | 23,460,602.4 | 25,398,337.5 | 27,271,972.1 | (1,873,634.6) | 107.4 |
| 3 | Нийт зардал | мян/төг | 20,889,734.7 | 23,512,927.8 | 19,872,479.3 | 3,640,454.5 | 84.5 |
| 4 | Татварын өмнөх ашиг | мян/төг | 2,570,867.7 | 1,885,409.7 | 7,399,492.9 | (5,514,083.1) | 392.5 |
| 5 | Цэвэр ашиг/алдагдал | мян/төг | 2,196,850.4 | 1,696,868.8 | 6,449,619.6 | (4,752,750.8) | 380.1 |
| 6 | Орлогын татварт | мян/төг | 374,017.3 | 188,541.0 | 949,873.2 | (761,332.2) | 503.8 |
| 7 | Төсвийн төлбөрт | мян/төг | 5,412,918.6 | 6,780,564.1 | 6,882,268.5 | (101,704.5) | 101.5 |
| 8 | Нийт авлага | мян/төг | 162,731.6 | 147,806.9 | 113,365.4 | 34,441.5 | 76.7 |
| 9 | Нийт өглөг | мян/төг | 6,779,085.2 | 5,794,517.0 | 6,529,173.2 | (734,656.2) | 112.7 |
| 10 | Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал | мян/төг | 0.89 | 0.93 | 0.78 | 0.15 | 84.0 |
| 11 | Ногдол ашгийн өглөг | мян/төг | 861,790.2 | 254,530.3 | 219,685.0 | 34,845.3 | 86.3 |
| 12 | Хөрөнгө оруулалт | мян/төг | 3,074,587.5 | 1,650,445.0 | 1,307,266.7 | 343,178.3 | 79.2 |

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал, аудитын санал дүгнэлт түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад урьдчилж төлсөн зардлын бүртгэл, шатахуун зарцуулалтын нормыг үндэслэлтэй батлах, борлуулсан бүтээгдэхүүний өртөг дансанд зардлын хуваарилалтыг холбогдох стандартын дагуу зөв ангилан бүртгэх талаар өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 3 дугаар сарын 05-наас 2022 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн хооронд ахлах аудитор Д.Болор-Эрдэнэ, гэрээт аудитор О.Наранбат нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер С.Нацагдорж, Аудитын хоёрдугаар газрын захирал, Тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

“Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 1/225 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Зам, тээврийн хөгжлийн яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдээгүй байна.

“Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын Хяналт-шинжилгээ, дотоод аудитын албанаас тайлант онд харьяа хэлтэс, алба, салбаруудад 4 чиглэлийн хүрээнд 33 ажилд үнэлгээ, дотоод аудитын хяналт шалгалт хийхээр төлөвлөгөө баталж, гүйцэтгэлээр 29 ажлыг бүрэн хийж гүйцэтгэн тухай бүр шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, цаашид алдаа дутагдлыг давтан гаргахгүй байх талаар зөвлөмж, санал дүгнэлт хүргүүлэн хэрэгжүүлэн ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

“Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын

дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 19,969.6 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 299.5 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4. Санхүүгийн тайлангийн тодруулга

4.1 Байгууллагын үйл ажиллагаа

“Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ нь Авто тээврийн хэрэгслээр ачаа, зорчигч тээвэрлэх үйл ажиллагааг боловсронгуй болгох, тээвэрлэлтийг мэргэшсэн жолоочоор гүйцэтгүүлэх авто үйлчилгээний байгууллагуудад ангилал тогтоох, авто тээврийн хэрэгсэлд тавигдах техникийн хяналт, тээврийн хэрэгслийн бүртгэлийг хэрэгжүүлэх, хөгжүүлэх, нийгмийн хэрэгцээг хангасан аюулгүй, ая тухтай үйлчилгээний нөхцөлийг бий болгох зорилго бүхий Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар юм.

Авто тээврийн тухай хууль, Засгийн газрын тогтоол болон компанийн дүрэмд заасны дагуу дараах чиглэлээр улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

- Авто тээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх;
- Монгол Улсын нутаг дэвсгэрт ашиглагдаж байгаа авто тээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох, шилжилт хөдөлгөөн бүртгэх, бүртгэлээс хасах, тээврийн хэрэгслийн гэрчилгээ болон улсын дугаар нөхөн олгох, авто тээврийн хэрэгслийн талаарх мэдээллийн сан, бүртгэлийн сүлжээ байгуулах, мэдээллээр хангах;
- Улс, хот хооронд орон нутгийн нийтийн зорчигч болон ачаа тээвэр, шуудан, жуулчин тээвэрлэлтийн үйлчилгээг улсын хэмжээнд зохицуулах, зохион байгуулах үйлчилгээг нийтийн зорчигч тээврийн ажил, үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ байгуулж гүйцэтгүүлэх;
- Улс, хот хооронд, орон нутгийн нийтийн зорчигч болон ачаа тээвэрлэлт гүйцэтгэж байгаа тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг шуурхай зохицуулалтаар хангах;
- Авто тээврийн хэрэгслийн мэргэшсэн жолоочийн шалгалт авах, үнэмлэх олгох;
- Улс, олон улс хоорондын зорчигч тээвэрлэлтийн үйлчилгээ эрхлэх;
- Авто үйлчилгээний байгууллагад ангилал тогтоох ажлыг зохион байгуулах;
- Төрийн захиалгат ажил, үйлчилгээг гэрээний үндсэн дээр гүйцэтгэх;
- Улс, хот хооронд, орон нутгийн ачаа, зорчигч тээвэрлэлт гүйцэтгэх аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг судлан, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаж буй эсэх талаар дүгнэлт гаргах, дүгнэлтийг авто тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, сумын Засаг даргад хүргүүлэх гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар гэсэн статустай, өмчийн 100 хувийг төр эзэмшиж байна.

4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 213 тогтоолоор “Тээврийн хэрэгслийн оношилгоо, хяналт зохицуулалт алба” улсын төсөвт үйлдвэрийн газрыг анх байгуулж, Засгийн газрын 2013 оны 336 дугаар тогтоолоор “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ -ыг өөрчлөн

байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;...” гэсэн заалттай нийцэж байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 55 дугаар тогтоолоор батлагдсан “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын дүрмийн 6.9, 6.12, 6.13 дахь заалт, байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 8.4 дэх хэсгийг тус тус үндэслэн үйлдвэрийн газрын захирлын 2017 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн А/123 дугаар тушаалаар “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын захирлын зөвлөлийг тэргүүн дэд дарга, дэд дарга, алба, хэлтсийн дарга нар буюу нийт 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан байна.

Мөн захирлын зөвлөлийн хуралдааныг зохион байгуулах, үүрэг даалгаврын биелэлтэд хяналт тавих журмыг баталсан бөгөөд тус зөвлөл нь 2021 онд 5 удаагийн хуралдаанаар 19 асуудал хэлэлцэн шийдвэрлэж, нэгжийн дарга нарт нийт 25 үүрэг чиглэл өгч, хэрэгжилтэд Хяналт-шинжилгээ, дотоод аудитын алба хяналт тавин ажиллаж байна.

Үйлдвэрийн газрын захирлын зөвлөлийн гишүүд нь эрхэлж буй албан тушаалын үндсэн цалин, урамшууллаар цалинжиж байгаа нь ТБОНӨТХ-ийн 21 дүгээр зүйлийн 12 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 3.7-д “...цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно. Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна” гэж заасантай нийцэж байна.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно” гэж заасан байна. Энэ хүрээнд Автотээврийн салбарын чанарын дэд бүтцийг бэхжүүлэх зорилт тавин үйлдвэрийн газрын Сонгинохайрхан, Баянгол, Баянзүрх техникийн хяналтын үзлэгийн төвүүд ISO 17020, Хэмжил зүйн лаборатори ISO 17025, Судалгаа, хөгжил, чанарын удирдлагын төв ISO 17065 олон улсын стандартын шаардлагыг тус тус ханган итгэмжлэгдэж, тохирлын үнэлгээний үйлчилгээг дараах гурван чиглэлээр хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Автотээврийн салбарт ашиглагдаж байгаа тоног, төхөөрөмжид шалгалт, тохируулга хийж, хэмжлийн нэгдмэл байдлыг хангуулах;
- Автотээврийн хэрэгслээс хүн амын эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн зөвшөөрөгдөх хэмжээний түвшин, тээвэрлэлтийн болон техник ашиглалтын шаардлагыг хангасан байдалд техникийн хяналт хийж, дүгнэлт гаргах;
- Автотээврийн салбарт үйлчилгээ эрхэлж байгаа нийтийн тээврийн байгууллагууд болон авто засварын газруудад үйлчилгээний баталгаажуулалт хийх;

Дээрх чиглэлүүдээр тохирлын үнэлгээний үйлчилгээг иргэд, аж ахуй нэгж байгууллагуудад үзүүлснээр автотээврийн салбарын үйлчилгээний чанар дээшилж, үйлчлүүлэгчид зөв сонголт хийхэд туслахаас гадна худалдаа тээврийг хөнгөвчлөн, автотээврийн салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, чанар, аюулгүй байдлын тогтолцоог бүрдүүлэх ач холбогдолтой арга хэмжээг авч ажилласан байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3-т “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар

хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх” заасны дагуу нийт зардлыг 15.5 хувиар хэмнэн ажилласан хэдий ч дэлхий нийтээр тархаад буй Коронавирус халдварт (COVID-19) цар тархалтын эсрэг хариу арга хэмжээ авах зорилгоор нийт 768 албан хаагчдад 367.2 сая төгрөгийн дархлаа дэмжих мөнгөн тусламжийг хавтгайруулан олгосон байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Монгол Улсын Их Хурлын 2021 оны 4 дүгээр сарын 08-ны өдрийн хуралдаанаар Автотээврийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг баталсан;
- Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Босго үнэ шинэчлэн батлах тухай” 124 дүгээр тогтоол;
- Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоол;
- Сангийн сайдын 2021 оны “Тушаалын хавсралт шинэчлэн батлах тухай” 190 дүгээр тушаал;
- Улсын Онцгой комиссын 2021 оны “Хот болон орон нутаг хооронд иргэдийн зорчих хөдөлгөөнийг зохицуулах түр журам” 46 дугаар тушаал;
- “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын захирлын 2021 оны “Тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарыг дуудлага худалдаагаар зохион байгуулах удирдамж” А/70 дугаар тушаал;

4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---------------------|---------------------|--------------------|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 1,814,904.3 | 9,880,402.4 | 8,065,498.1 |
| Авлага | 160,631.5 | 99,765.4 | (60,866.1) |
| Урьдчилгаа | 1,137,439.2 | 123,639.6 | (1,013,799.6) |
| Бараа материал | 2,033,329.6 | 1,967,496.5 | (65,833.1) |
| Үндсэн хөрөнгө | 32,215,814.9 | 32,377,765.7 | 161,950.8 |
| Биет бус хөрөнгө | 6,703,629.2 | 6,613,904.1 | (89,725.1) |
| Нийт хөрөнгийн дүн | 44,065,748.8 | 51,062,973.7 | 6,997,224.9 |
| Богино хугацаат өглөг | 756,974.7 | 1,235,131.0 | 478,156.3 |
| Урт хугацаат өглөг | 6,022,110.5 | 5,383,711.7 | (638,398.8) |
| Эздийн өмч | 37,286,663.6 | 44,444,131.0 | 7,157,467.4 |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 44,065,748.8 | 51,062,973.7 | 6,997,224.9 |

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, урьдчилж төлсөн зардал, үндсэн хөрөнгийн данстад материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 9,880.4 сая төгрөг болж, 8,065.5 сая төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд бүртгэлийн үйлчилгээний үнэ, хөлсийг шинэчилснээр орлого нэмэгдэж, дээд газрын шийдвэрээр зардлын хэмнэлттэй ажиллаж, 28 салбарын 152 харилцах дансны 43.4 сая, төв салбарын хугацаатай хадгаламжийн дансанд байршуулсан 4,031.6 сая, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогын 31 дансны 5,805.4 сая төгрөгийн зарцуулаагүй үлдэгдэлтэй байна.

Авлага дансны үлдэгдэл 99.8 сая төгрөг болж, 60.9 сая төгрөгөөр буурсан нь 2008-2020 онуудад үүссэн 26.2 сая, тайлант хугацаанд үүссэн 26.7 сая, байгууллагаас авах авлага 25.4 сая төгрөг, хууль хяналтын байгууллагаар шийдэгдэх 36.2 сая төгрөгийн авлага барагдуулах үйл ажиллагаа хүлээгдсэн нь нөлөөлсөн байна.

Урьдчилгаа дансны үлдэгдэл 123.6 сая төгрөг болж, 1,013.8 сая төгрөгөөр буурсан нь тайлант хугацаанд 64.0 сая төгрөгийн урьдчилгаа төлбөр нэмэгдэж, 1,100.0 сая төгрөгийн өртөгтэй Баянхонгор аймгийн Автотээврийн төвийн барилга байгууламжийн улсын бүртгэлийн гэрчилгээ болон ТӨБЗГ-ын 2019 оны 406 дугаар тогтоолыг үндэслэн үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлэн бүртгэсэн нь голлон нөлөөлсөн бөгөөд дансны үлдэгдэлд 91.0 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгийн шинжтэй дууссан ажил гүйлгээ бүртгэлтэй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 1,967.5 сая төгрөг болж, 65.8 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд худалдан авалт 2,321.8 сая төгрөгөөр нэмэгдэж, үйлдвэрийн газрын захирлын 2021 оны А/243 дугаар тушаалаар цаашид ашиглах сэргээх боломжгүй 4,189 ширхэг 138.1 сая төгрөгийн бараа материал болон ашиглалтын хугацаа дууссан, цаашид ашиглагдахгүй 53,449 ширхэг 5.6 сая төгрөгийн маягт, үнэт цаасыг акталж, данс бүртгэлээс хассан байна.

Оны эцэст бараа материалын нөөц үүсгэсэн нь 29 салбарын ашиглалтад байгаа хангамжийн материал 936.0 сая төгрөг буюу нийт бараа материалын үлдэгдлийн 47.6 хувийг, сэлбэг хэрэгсэл 378.6 сая төгрөг буюу 19.2 хувийг, 504.5 сая төгрөг буюу 25.6 хувийг маягт, үнэт цаас тус тус эзэлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 32,377.8 сая төгрөг болж, 162.0 сая төгрөгөөр өссөн байна. Үүнд:

Үндсэн хөрөнгийн орлого:

- “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын эдийн засгийн зорилтод түвшинд тусгагдсан 2021 оны хөрөнгө оруулалтаар 135.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн;
- ТӨБЗГ-ын 2021 оны А-1/793, А-1/1079 дүгээр албан бичгээр нийт 26.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн;
- Он дамжсан 1,100.0 сая төгрөгийн өртөгтэй Баянхонгор аймгийн Автотээврийн төвийн барилга байгууламж, 33.9 сая төгрөгийн компьютер техник хэрэгсэл;
- ТӨБЗГ-ын 2021 оны 90 дүгээр тогтоолоор “Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨХХК-аас 17.2 сая төгрөгийн балансын үнэ бүхий автомашин;
- ТӨБЗГ-ын 2021 оны 313 дугаар тогтоолоор Говь-Алтай болон Ховд аймгийн Автотээврийн төвөөс элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 1.0 сая төгрөгийн 2 ширхэг чиргүүл;
- Баян-Өлгий, Дархан-Уул, Дорноговь аймгийн Автотээврийн төвүүд 13 нэр төрлийн 15 ширхэг тавилга эд хогшил, 1 ширхэг суудлын автомашин, 1 ширхэг жийп автомашиныг балансаас балансад шилжүүлэн бүртгэсэн.

Үндсэн хөрөнгийн зарлага:

- ТӨБЗГ-ын 2020 оны 760 дугаар тогтоолоор ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 28.0 сая төгрөгийн балансын үнэ бүхий 1 ширхэг автомашиныг нээлттэй дуудлага худалдаагаар 9.3 сая төгрөгөөр;
- ТӨБЗГ-ын 2021 оны 95, 452 дугаар тогтоолоор элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид ашиглах боломжгүй нийт 47.8 сая төгрөгийн балансын үнэтэй 4 ширхэг автомашиныг сэлбэгийн зориулалтаар 4.8 сая төгрөгөөр худалдсан;
- ТӨБЗГ-ын 2020 оны 769 дүгээр тогтоолоор Замын-Үүд дахь Гаалийн дахин төлөвлөлтөд орсон тус салбарын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 35.5 сая төгрөгийн балансын үнэ бүхий 24.7 сая төгрөгийн үлдэх өртөгтэй хяналтын байрыг;
- ТӨБЗГ-ын 2021 оны А-1/831 дүгээр албан бичгийг үндэслэн тус төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн,

эрүүгийн хэрэгт эд мөрийн баримтаар хураагдсан 2.4 сая төгрөгийн балансын үнэтэй 1 ширхэг иж бүрэн суурин компьютерыг;

- ТӨБЗГ-ын 2021 оны 516 дугаар тогтоолоор үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 371 нэрийн 988.5 сая төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийг үйлдвэрийн газрын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтад тус тус акталж, данснаас хассан.

Биет бус хөрөнгө 6,613.9 сая төгрөг болж, 89.7 сая төгрөгөөр буурсан нь тайлант оны худалдан авах ажиллагаагаар 19.9 сая төгрөгийн тээврийн хэрэгслийн улсын дугаарын дуудлага худалдааны программ худалдаж авсан, 145.8 сая төгрөгийн тээврийн хэрэгслийн хяналтын Wialon local программын өргөтгөл, 8.0 сая төгрөгийн тээврийн хэрэгслийн нэгдсэн системийн өргөтгөлийг капиталжуулж, Баянхонгор аймгийн Автотээврийн төвийн барилгын 17.4 сая төгрөгийн эзэмшлийн газрыг тус тус нэмж бүртгэсэн, ТӨБЗГ-ын 2021 оны 371 дүгээр тогтоолыг үндэслэн 29.9 сая төгрөгийн ашиглалтын шаардлага хангахгүй программ хангамж, 7.1 сая төгрөгийн зураг төслийг акталж данснаас хасаж, тайлант хугацааны хорогдуулалт бүртгэсэнтэй холбоотой байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 1,235.1 сая төгрөг болж, 478.2 сая төгрөгөөр өссөн нь Хүүхдийн төлөө санд төвлөрүүлэх 132.2 сая төгрөгийн дуудлага худалдааны орлого, хөрөнгө оруулалтын ажлын үлдэгдэл 51.1 сая, НӨАТ болон ААНОАТ-ын жилийн эцсийн тайлангийн өр төлбөр 737.6 сая, ажил үйлчилгээ үзүүлсний дараа орлогоор хүлээн зөвшөөрөх 234.6 сая төгрөг бүртгэлтэй байгаагаас шалтгаалжээ.

Урт хугацаат өр төлбөр нь Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 336 дугаар тогтоолын 3 дахь заалтын дагуу 2001 онд Тээврийг хөгжүүлэх төслийн хүрээнд 3,940.000 SDR /зээлжих тусгай эрхтэй/ тэнцэх зээлийг хуучнаар Санхүү, эдийн засгийн яам болон Автотээврийн газар хоорондын NDF-353 дугаар Нордикын хөгжлийн сангаар дамжуулан зээлдүүлэх 6,636.6 сая төгрөгийн урт хугацаат зээлийн үндсэн төлбөрт 3,753.9 сая төгрөг, тайлант хугацааны хүүгийн зардалд 160.9 сая төгрөгийг хуваарийн дагуу төлж, 5,271.2 сая төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна.

Эздийн өмч дансны үлдэгдэл 44,444.1 сая төгрөг болж, 7,157.5 сая төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд 6,449.6 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласнаас голлон шалтгаалсан байна.

Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл данс 830.0 сая төгрөгөөр нэмэгдсэн нь өмнөх оны аудитын зөвлөмж, НБББББ-ийг үндэслэн үйлдвэрийн газрын захирлын 2021 оны А/276 дугаар тушаалаар 34 ширхэг 1,704.2 сая төгрөгийн өртөгтэй тоног төхөөрөмж, 21 ширхэг 824.1 сая төгрөгийн өртөгтэй тээврийн хэрэгсэл, 62.1 сая төгрөгийн балансын үнэтэй 2 нэгжийн дэд бүтцийг ажлын хэсгийн дүгнэлтээр дахин үнэлгээ хийж, данс бүртгэлд тусгаснаас шалтгаалсан байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөг, үйл ажиллагааны зардал, үйл ажиллагааны бус зардал гэж ангилсан байна.

Үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөгт салбаруудын нийт зардлуудыг хамруулсан байна. Үүнээс ерөнхий ба удирдлагын зардал, борлуулалт, маркетингийн зардал өртөгт хуваарилагдахгүй зардлууд байна. НБББББ-т “үзүүлсэн ажил үйлчилгээний өртөг-ҮАБӨ хэсэгт үндсэн ажил үйлчилгээг үзүүлж буй салбаруудад гарсан бүх зардал, тэдгээрийг мэргэжлийн удирдлагаар хангаж буй ... бүх зардлууд бүртгэгдэнэ” гэж заасан нь НББОУС-2 бараа материалд заасантай нийцэхгүй байна.

4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ нь үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 611 дүгээр тогтоолоор “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 25,398.3 сая төгрөгөөр, нийт зардлыг 23,512.9 сая төгрөгөөр, 1,885.4 сая төгрөгийн ашигтай ажиллахаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 1,650.4 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 27,272.0 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 19,872.5 сая төгрөгийг зарцуулж, 6,449.6 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна. Орлогын эх үүсвэр нь үндсэн үйл ажиллагааны орлогоос бүрджээ.

Хүснэгт 2. 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин /сая төгрөг/

| № | Үзүүлэлт | Хэмжих нэгж | 2020 оны гүйцэтгэл | 2021 он | | Зөрүү | Хувь |
|---------|--------------------------------------|----------------------|--------------------|-----------------|-----------------|------------------|--------------|
| | | | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| 1 | Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт | | | | | | |
| Үүнээс: | Техникийн хяналт оношилгоо | тоо хэмжээ | 13,103.7 | 12,838.8 | 13,827.0 | (988.2) | 107.7 |
| | Зорчигч тээвэр | зорчигч, ачаа эргэлт | 7,655.6 | 8,046.2 | 5,099.1 | 2,947.0 | 63.4 |
| | Бүртгэл, Бусад | сая /төг | 2,701.2 | 4,513.4 | 8,345.9 | (3,832.5) | 184.9 |
| 2 | Нийт орлого | сая /төг | 23,460.5 | 25,398.3 | 27,272.0 | (1,873.6) | 107.4 |
| | Нийт зардал | сая /төг | 20,889.7 | 23,512.9 | 19,872.5 | 3,640.4 | 84.5 |
| 3 | Үүнээс: Ерөнхий ба удирдлагын зардал | сая /төг | 1,356.1 | 1,294.1 | 826.4 | 467.7 | 63.9 |
| 4 | Хөрөнгө оруулалт | сая /төг | 3,074.5 | 1,650.4 | 1,307.2 | 343.2 | 79.2 |
| 5 | Цэвэр ашиг/алдагдал | сая /төг | 2,196.8 | 3,342.1 | 6,449.6 | (3,107.5) | 193.0 |

Орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл:

Нийт орлогын гүйцэтгэл 27,272.0 сая төгрөг болж, төлөвлөснөөс 1,873.6 сая төгрөг буюу 7.4 хувиар давсан нь тээврийн хэрэгслийн бүртгэлийн орлого төвлөрүүлэлтээс голлон шалтгаалсан байна.

Техникийн хяналтын үзлэгийн орлого: Нийт орлогын 50.7 хувийг эзэлж байгаа бөгөөд орлогын гүйцэтгэл төлөвлөснөөс 988.2 сая төгрөгөөр өссөн нь 611 мянган тээврийн хэрэгслийг үзлэг оношилгоонд хамруулж, орлогыг 7.7 хувиар давуулан биелүүлсэн, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Тээвэр зохицуулалтын орлого: Нийт орлогын 18.7 хувийг эзэлж байгаа бөгөөд орлогын гүйцэтгэл төлөвлөснөөс 2,947.2 сая төгрөгөөр буурсан нь улс хоорондын байнгын ачаа тээвэрлэлтэд ашиглагдах “С” төрлийн зорчих зөвшөөрлийн бичгийг үүсээд байгаа цар тахлын нөхцөл байдалтай уялдуулан “Хилийн боомтын зөвлөл”-өөс гаргасан шийдвэрийн дагуу халдвар хамгааллын шаардлага хангасан “Битүүмжилсэн тээврийн баг”-т олгосноор зөвшөөрлийн бичгийн орлого 25.2 хувиар тасарсан байна.

Мөн Улсын Онцгой комиссын 2021 оны 46 дугаар тушаалаар баталсан “Хот болон орон нутаг хооронд иргэдийн зорчих хөдөлгөөнийг зохицуулах түр журам”-ын хүрээнд вакцинжуулалт, эмнэлгийн магадалгаа, түргэвчилсэн шинжилгээний хариутай эсэхийг шалган хот хоорондын зорчих хөдөлгөөнийг нээсэн, коронавируст халдварын тархалт өндөртэй орон нутгаас зорчих хөдөлгөөнийг хязгаарлах зэрэгтэй холбогдуулан тус үйлдвэрийн газраас зохицуулалт хийж тээврийн хэрэгслийн гаралтыг багасгах, давтамжийг бууруулах зэрэг арга хэмжээ авч ажилласнаар зорчигч урсгалын тоо 556.9 мянга хүртэл буурч, тээврийн болон ачаа тээшний орлого дунджаар 72.0 хувиар тасарсан байна.

Тээврийн хэрэгслийн бүртгэлийн орлого: Нийт орлогын 24.1 хувийг эзэлж байгаа бөгөөд орлогын гүйцэтгэл төлөвлөснөөс 3,342.5 сая төгрөгөөр өссөн нь АТҮТ ТӨҮГ-ын захирлын 2020 оны А/286 дугаар тушаалаар тээврийн хэрэгслийн бүртгэл үйлчилгээний

тарифыг нэмэгдүүлэн шинэчлэн тогтоосон, мөн сонирхол татахуйц дугааруудыг дуудлага худалдаагаар борлуулснаар 104.522 тээврийн хэрэгслийг шинээр, 491.648 тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөн, 105.921 улсын дугаар солилт, 14.563 гэрчилгээ нөхөлтийг тус тус бүртгэж, бүртгэлийн орлогыг 103.0 хувиар давуулан биелүүлснээс шалтгаалсан байна.

Үйлдвэрийн газрын захирлын 2021 оны А/70 дугаар тушаалаар батлагдсан “Тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарыг дуудлага худалдаагаар зохион байгуулах журам”-ын дагуу тайлант онд сонирхол татахуйц нийт 2044 дугаарын 3,668.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 60.4 сая төгрөгийг дуудлага худалдааны үйл ажиллагааны зардалд зарцуулж, 3,451.3 сая төгрөгийг Улсын Их хурлаас 2021 онд баталсан Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Автотээврийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийг үндэслэн Хүүхдийн төлөө санд төвлөрүүлж, 156.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Хөдөлгөөний хяналт, удирдлагын орлого: Нийт орлогын 5.0 хувийг эзэлж байгаа бөгөөд орлогын гүйцэтгэл төлөвлөснөөс 361.5 сая төгрөгөөр өссөн нь 1900-1234 тусгай дугаарын лавлах үйлчилгээнд ойролцоогоор 290 мянган дуудлага хүлээн авч, 178 аж ахуйн нэгж байгууллагын хүсэлтээр 6206 тээврийн хэрэгсэлд GPS программын үйлчилгээ үзүүлсэнтэй холбоотой байна.

Зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл:

Нийт зардлын гүйцэтгэл 19,872.5 сая төгрөг болж, төлөвлөснөөс 3,640.4 сая төгрөг буюу 15.5 хувиар дутуу гүйцэтгэлтэй байна. Энэ нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол, ТӨБЗГ-ын 2020 оны өдрийн А-1/2385 дугаар албан даалгаврыг хэрэгжүүлэн хэмнэлтийн горимд шилжиж, батлагдсан зардлыг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж ажилласантай холбоотой байна.

Хүснэгт 3. 2021 оны нийт зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөг/

| Эдийн засгийн ангилал | 2021 он | | Хэтрэлт, хэмнэлт | Хувь |
|---|-----------------|-----------------|------------------|-------------|
| | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| Нийт зардал | 23,512.9 | 19,872.5 | 3,640.4 | 84.5 |
| Үйл ажиллагааны зардал | 21,142.2 | 17,400.8 | 3,741.4 | 82.3 |
| 1. Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал | 13,177.3 | 11,765.1 | 1,412.2 | 89.3 |
| 2. Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 2,035.9 | 1,592.1 | 443.8 | 78.2 |
| 3. Байгууллагын тогтмол зардал | 1,930.9 | 1,322.2 | 608.7 | 68.5 |
| 4. Байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зардал | 494.0 | 366.3 | 127.7 | 74.1 |
| 5. Эд хогшлын зардал | 362.0 | 331.1 | 30.9 | 91.5 |
| 6. Томилолт, зочны зардал сургалт | 440.5 | 230.7 | 209.8 | 52.4 |
| 7. Бусад бараа үйлчилгээний зардал | 2,701.6 | 1,905.9 | 795.7 | 70.5 |
| Элэгдлийн зардал | 2,370.8 | 2,359.2 | 11.5 | 99.5 |

Тайлант онд үргэлжилсэн (COVID-19) цар тахлын үед Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэг “Улаан” түвшинд шилжихэд Хөдөлмөрийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1, 56.2-т заасны дагуу сул зогсолт зарлаж, ажилчдын цалин хөлсийг 60.0 хувиар тооцон олгосон, мөн түрээслүүлэгч байгууллагуудад түрээсийн төлбөрөөс хөнгөлөлт үзүүлэхэд хамтран ажиллах талаар хүсэлт хүргүүлснээр Тээврийн хэрэгслийн бүртгэлийн үйл ажиллагааг иргэдэд хүргэж буй “Таванган трейд” ХХК, “Хөсөг трейд” ХХК, “Биг автомолл партерс” ХХК, “Лавай” ХХК, “Баялаг Онон” ХХК зэрэг байгууллагууд үйлчилгээний заалны түрээсийг 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 7 дугаар сарын 31, 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл тус тус түрээсийн хөнгөлөлт үзүүлснээр түрээсийн зардлыг хэмнэж ажилласан байна.

Нийт зарцуулалтын хэмнэлтийг бүлгийн дүнгээр авч үзвэл:

- Цалин, хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 13,177.3 сая төгрөгөөр төлөвлөж, 11,765.1 сая төгрөг зарцуулж, 1,412.2 сая төгрөгийн буюу 10.7 хувийн хэмнэлт;
- Нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 2,035.8 сая төгрөгөөр төлөвлөж, 1,592.1 сая төгрөг зарцуулж, 443.8 сая төгрөгийн буюу 21.8 хувийн хэмнэлт;
- Байгууллагын тогтмол зардлыг 1,930.9 сая төгрөгөөр төлөвлөж, 1,322.2 сая төгрөг зарцуулж, 608.7 сая төгрөгийн буюу 31.5 хувийн хэмнэлт;
- Байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зардлыг 494.0 сая төгрөгөөр төлөвлөж, 366.3 сая төгрөг зарцуулж, 127.7 сая төгрөгийн буюу 25.9 хувийн хэмнэлт;
- Эд хогшил худалдан авах зардлыг 362.0 сая төгрөгөөр төлөвлөж, 331.1 сая төгрөг зарцуулж, 30.9 сая төгрөгийн буюу 8.5 хувийн хэмнэлт;
- Томилолт, зочин төлөөлөгч, сургалтын зардлыг 440.5 сая төгрөгөөр төлөвлөж, 230.7 сая төгрөг зарцуулж, 209.8 сая төгрөгийн буюу 47.6 хувийн хэмнэлт;
- Бусад бараа үйлчилгээний зардлыг 2,701.6 сая төгрөгөөр төлөвлөж, 1,905.9 сая төгрөг зарцуулж, 795.7 сая төгрөгийн буюу 29.5 хувийн тус тус хэмнэлт үүсгэсэн;
- Элэгдлийн зардлыг 2,370.8 сая төгрөгөөр төлөвлөж, 2,359.2 сая төгрөгийн элэгдлийн зардал байгуулж, 11.5 сая төгрөгийн буюу 99.5 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 17 нэр төрлийн 22 багц ажилд өөрийн эх үүсвэрээс 1,307.2 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Тайлант онд цэвэр ашиг 6,449.6 сая төгрөг болж, төлөвлөснөөс 4,752.7 сая төгрөгөөр илүү байгаа нь техник хяналт үзлэгийн, бүртгэлийн, хөдөлгөөн хяналт удирдлагын орлогын өсөлт болон зардлын бодит хэмнэлт нөлөөлсөн байна.

ТӨБЗГ-ын 2021 оны 228 дугаар тогтоол, мөн 2021 оны А-1/1104 дүгээр албан бичгийн дагуу тайлант онд 219.7 сая төгрөгийн ногдол ашгийг ТӨБЗГ-т бүрэн төвлөрүүлсэн байна.

Мөн ТӨБЗГ-т түрээсийн орлогын 40.0 хувь болох 65.4 сая, улсын төсөвт улсын тэмдэгтийн хураамжийн 1,252.4 сая төгрөгийг тус тус төвлөрүүлжээ.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт, орлого, зардлын зүйлс тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст нийт 4196 мэдээлэл байршуулахаас 42 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 2 мэдээлэл, 246.3 сая төгрөгийн тушаал шийдвэрийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т *"тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх"*, 6 дугаар зүйлийн 6.4.5-д *"цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр"*, 6.4.8-д *"бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр"*, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны *"Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам"* 29 дүгээр тогтоолын холбогдох заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх онд өгөгдсөн албан шаардлага хэрэгжээгүй, зөрчлийг давтан гаргасан тул хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэх

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд хөрөнгө оруулалтын 9 нэр төрлийн 10 багц 1,650.4 сая, урсгал зардлын шинж чанартай 7 нэр төрлийн 7 багц бүхий 319.4 сая төгрөг нийт 1,969.8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 16 нэр төрлийн 17 багц бүхий худалдан авах ажиллагаа төлөвлөгдсөнөөс Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол, ТӨБЗГ-ын 2021 оны А-1/354 дүгээр албан даалгаврыг үндэслэн 344.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий худалдан авах ажиллагааг зогсоож хэмнэлтийн горимд шилжсэн байна.

Гүйцэтгэлээр худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулан ажиллаж, их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээнд 11 нэр төрлийн 13 багц ажилд өөрийн эх үүсвэрээс 1,307.3 сая, урсгал зардлын 6 нэр төрлийн 236.3 сая төгрөг нийт 1,543.6 сая төгрөгийн буюу 80.0 хувийн гүйцэтгэлтэй байна.

Худалдан авах ажиллагаа зохион байгуулж гэрээ байгуулалгүй 24.5 сая төгрөгийг Андууд БГБХН-д шилжүүлж, шууд худалдан авалт хийж гүйцэтгэсэн байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т *"Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ"*, 8.4-д *"Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно"* 8.5-д *"Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно"*, 34 дүгээр зүйлийн 34.1-т *"Гэрээ шууд байгуулах аргыг зөвхөн дараахь нөхцөлд хэрэглэж болно"* гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг мөрдөж ажиллах албан шаардлага хүргүүлэх

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалтуудтай, худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж, заавар журамтай тус тус нийцээгүй байна гэж дүгнэлээ.

6. Өмнөх аудитын зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 580.8 сая төгрөгийн зөрчилд 9 албан шаардлага хүргүүлж, 603.3 сая төгрөгийн зөрчилд 27 зөвлөмж өгсөн хэрэгжилт 83.3 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 4. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|-----------------|---------------------|----------------|-----------|----------------|----------|-------------|-------------|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Албан шаардлага | 9 | 580.8 | 6 | 561.2 | 3 | 19.6 | 66.7 |
| Зөвлөмж | 27 | 603.3 | 27 | 603.3 | - | - | 100.0 |
| Нийт дүн | 36 | 1,184.1 | 33 | 1,164.5 | 3 | 19.5 | 83.3 |

Төрд учруулсан хохирлыг буруутай шийдвэр гаргасан албан тушаалтнаар нөхөн төлүүлэх 19.6 сая төгрөгийн албан шаардлагад төлбөрийн акт тогтоож, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт болон 28 салбарын санхүүгийн тайлан бэлтгэхтэй холбоотой албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй тул хариуцлага тооцох албан шаардлага тус тус хүргүүлэв.

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөгдөж эхэлсэнтэй холбоотой цалин урамшуулал, дундаж цалин хөлс тооцох, илүү цаг болон шөнийн цагийн нэмэгдлийг хэрхэн тооцох аргачлал, дүрэм журам батлагдаагүй тул дараагийн аудитаар цалин урамшууллын зардалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлж үзэх нь зүйтэй гэж үзлээ.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,015.1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 774.1 сая төгрөгийн 4 алдааг залруулж, 19.6 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 56.1 сая төгрөгийн зөрчилд 7 албан шаардлага хүргүүлж, 165.3 сая төгрөгийн алдаа зөрчилд 23 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй алдаа, зөрчлийн дүн 241.0 сая төгрөг нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 299.5 сая төгрөгөөс хэтрээгүй тул “Зөрчилгүй” дүгнэлт өглөө.

8.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 774.1 сая төгрөгийн 4 алдааг залрууллаа. Үүнд:

- Санхүүгийн байдлын тайлангийн хойшлогдсон татварын өр дансны үлдэгдэл 112.5 сая төгрөгийг үндэслэлгүй хаасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө", 6.3.2-т "санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах", НББОУС-1-д заасантай нийцэхгүй байна.
- Мөнгөн гүйлгээний тайлангийн үндсэн хөрөнгө борлуулсны орлого 14.2 сая төгрөгийг дутуу тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө", 6.3.2-т "санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах", НББОУС-1-д заасантай нийцэхгүй байна.
- НӨАТ-ын жилийн эцсийн тайлангийн өр төлбөр 352.0 сая төгрөгийг хуулийн хугацаанд улсын төсөвт төвлөрүүлээгүй нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-т "Албан татвар суутган төлөгч нь борлуулсан бараа, ажил, үйлчилгээнд ногдох албан татварыг доор дурдсан журмаар дараа сарын 10-ны өдрийн дотор төрийн сангийн нэгдсэн дансанд шилжүүлж, баталсан маягтын дагуу тайлангаа харьяалах татварын албанд тушаана", НББОУС-7-д заасныг зөрчсөн тул аудитын явцад холбогдох татварын дансанд төвлөрүүлсэн.

- ААНОАТ-ын жилийн эцсийн тайлангийн өр төлбөр 295.4 сая төгрөгийг хуулийн хугацаанд улсын төсөвт төвлөрүүлээгүй нь Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 24.5-т "Суутган ногдуулсан албан татварыг ажлын 10 өдрийн дотор төсөвт шилжүүлнэ" НББОУС-12-д заасныг зөрчсөн тул аудитын явцад холбогдох татварын дансанд төвлөрүүлсэн.

8.2 Төлбөрийн акт

Өмнөх оны аудитаар төрд учруулсан 19.6 сая төгрөгийн хохирлыг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэхээр хүргүүлсэн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-т "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ", Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан 2020 оны А/95 дугаар журмын холбогдох заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Шүүхийн шийдвэрээр ажлаас үндэслэлгүйгээр халагдсан ажилтанд олгосон нөхөн олговрыг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох

8.3 Албан шаардлага

1. Дуудлага худалдаа зохион байгуулах журмыг зөрчин сонирхол татахуйц дугаарын дуудлага худалдааны орлогоос зөөврийн компьютер, принтер, баримт үдэгч, камер, утасны аппарат зэрэг 31.6 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэж зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 21.2.2-т "Хүүхдийн төлөө сангийн хөрөнгийн эх үүсвэр нь энэ хуулийн 6.1.1, 6.1.2-т зааснаас гадна дараах эх үүсвэрээс бүрдэнэ", 21.2.2.1-т "автотээврийн хэрэгслийн сонирхол татахуйц улсын бүртгэлийн дугаар борлуулсны орлого", Автотээврийн тухай хуулийн 17.1.3-т "Автотээврийн хэрэгслийн сонирхол татахуйц улсын бүртгэлийн дугаарыг үнэ хаялцуулах дуудлага худалдаагаар борлуулж болно", 7.1.4-т "энэ хуулийн 17.1.3-т заасан орлогыг Хүүхдийн төлөө санд төвлөрүүлнэ", Монгол Улсын Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 1/1385 дугаар албан бичиг, АТҮТ ТӨҮГ-ын захирлын 2021 оны А/70 дугаар тушаалаар баталсан "Тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарыг дуудлага худалдаагаар зохион байгуулах удирдамж"-ын 2.13-т "дуудлага худалдааны үйл ажиллагааны зардалд дараах зүйлс хамаарна. Үүнд: Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр зар мэдээ явуулсан зардал, программ хангамж хөгжүүлэлтийн зардал, дансны шимтгэл, сурталчилгааны зардал, бусад" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Дуудлага худалдааны үйл ажиллагааны зардлыг журмын дагуу санхүүжүүлж, үлдэгдэл орлогыг Хүүхдийн төлөө санд бүрэн төвлөрүүлж байх албан шаардлага хүргүүлэх

2. Үйлдвэрийн газрын захирлын 2021 оны А/322 дугаар тушаалаар дархлаа дэмжих зорилгоор нийт 768 албан хаагчдад 367.2 сая төгрөгийн буцалтгүй тусламжийг хавтгайруулан олгосон байна.

Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.3-т " төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, зардлыг үр ашигтай төлөвлөж, зарцуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх

3. Драгон холдинг ХХК-тай байгуулсан 2016 оны ХХАГ16/020 дугаар гэрээт 2,888.5 сая төгрөгийн 979.14 м.кв бүхий оффисын талбайн, мөн гэрээний 3.1.8-д заасан 3634.9 м.кв авто зогсоолын эзэмшлийн гэрчилгээг гэрээнд заасан хугацаанд гаргаж, үндсэн хөрөнгийн дансанд бүртгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2 "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.2-т "Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна", ТӨБЗГ-ын 2016 оны 55 дугаар тогтоолын 6.10.8-д "үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгө худалдан авах болон акталж, устгах, худалдах, шилжүүлэх асуудлыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тавьж шийдвэрлүүлэх", ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолд заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Үл хөдлөх хөрөнгийн улсын бүртгэлийн гэрчилгээг гаргуулж, үндсэн хөрөнгөнд бүртгэх албан шаардлага хүргүүлэх

4. Мөнгөн хөрөнгийг арилжааны банканд байршуулахдаа холбогдох журмыг мөрдөөгүй, эрсдэлийн үнэлгээ, хадгаламжийн дундаж хүүгийн түвшинг тооцолгүй нийт 4,000.0 сая төгрөгийг ХХБ-нд 6.0%, Төрийн банканд 5.7%, Хаан банканд 5.5%-ийн хүүтэй 3 сарын хугацаатай байршуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3-т "үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах", 67 дугаар зүйлийн 67.1-д "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна", Сангийн сайд, Монгол банкны ерөнхийлөгчийн хамтарсан тушаалд заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Арилжааны банканд мөнгөн хөрөнгө байршуулах журам боловсруулж, мөрдөн ажиллах албан шаардлага хүргүүлэх

5. “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын харьяа 28 салбарын санхүүгийн тайланг бэлтгэж гаргах тухай Үндэсний аудитын газрын 2021 оны 297/A0170067 дугаар албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.11-т "нэгтгэсэн санхүүгийн тайлан" гэж Компанийн тухай хуулийн 6.4-т заасан санхүүгийн тайланг", 4.1-т "Аж ахуйн нэгж, байгууллага дараах бүртгэлийн стандартыг дагаж мөрдөнө", Компанийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т "Компанийн нийт гаргасан энгийн хувьцааны 20-50 хувийг өөр /толгой/ компани дангаараа буюу нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа тохиолдолд уг компанийг хараат компани гэнэ", 6.2-т "Хараат компани нь бие даасан тайлан баланс гаргадаг хуулийн этгээд байна" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Харьяа салбар нэгжүүдийг улсын бүртгэлийн гэрчилгээтэй болгох, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй тул хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэх

8.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1.Урьдчилж төлсөн зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Урьдчилгаа дансны үлдэгдэлд өмнөх он болон тайлант хугацаанд хэрэгжиж дууссан зураг төслийн 4 ажлын нийт 91.0 сая төгрөг бүртгэлтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "жинхэнэ хэрэгжилтийн", 5.1.4-т "үнэн зөв байх", 6 дугаар зүйлийн 6.1-т "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузл сууриар хөтөлнө", 6.3.2-т "санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Урьдчилгаа дансанд он дамжсан буюу дараа онд хүлээн зөвшөөрөх зардлыг бүртгэж, зардлаар хүлээн зөвшөөрөх

2. Зардлын хэмнэлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Шатахуун зарцуулалтын нормыг захирал өдөрт 150км, дэд дарга 100км, 4 хэлтсийн дарга 85км-ээр тооцон баталсныг Засгийн газрын 184 дүгээр тогтоолоор баталсан нормтой харьцуулахад нийт 14.9 сая төгрөгийн хэмнэж болох зардлыг илүү олгож, үр ашиггүй зарцуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3-т "үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах", 67 дугаар зүйлийн 67.1-д "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна", Засгийн газрын 2015 оны 184 дүгээр тогтоолд заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сар бүрийн шатахуун зарцуулалтын нормыг шинэчлэн баталж, хэрэгжүүлж ажиллах

3. НБББББ-тэй холбоотой асуудал

Илрүүлэлт: НБББББ-т зааснаар борлуулсан бүтээгдэхүүний өртөгт салбар нэгжүүдийн нийт зардлыг тусган тайлагнаж байгаа нь байгууллагын нийт ашгийн үзүүлэлт, үйл ажиллагааны ашгийн тооцоог буруу илэрхийлж, удирдлагад стратегийн шийдвэр оновчтой гаргахад сөргөөр нөлөөлж байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", НББОУС-2 стандарттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Борлуулсан бүтээгдэхүүний өртөгт шингэх зардлыг холбогдох стандартын дагуу хуваарилан бүртгэж, санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэж гаргах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Д/д | Байгууллагын нэр, аудитын код | Алдаа зөрчлийн утга | Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга | Нийт алдаа, зөрчлийн дүн | | Үүнээс | | | | | | | | | |
|--|--|--|--|--------------------------|-----------|-----------|-----------|-----|----------|-----------------|----------|-------------------|-----|---------|-----|
| | | | | | | Залруулга | | Акт | | Албан шаардлага | | Хариуцлага тооцох | | Зөвлөмж | |
| | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайлангийн асуудлаар | | | | | | | | | | | | | | | |
| 1 | Автотээврийн үндэсний төв АХГ-2022/26/НА-СТА-ТӨА | Санхүүгийн байдлын тайлангийн хойшлогдсон татварын өр дансны үлдэгдэл 112,481.8 мянган төгрөгийг үндэслэлгүй хаасан байна. | Санхүүгийн тайланд залруулах | 1 | 112,481.8 | 1 | 112,481.8 | | | | | | | | |
| 2 | | Мөнгөн гүйлгээний тайлангийн үндсэн хөрөнгө борлуулсны орлого 14,150.0 мянган төгрөгийг дутуу тайлагнасан байна. | Санхүүгийн тайланд залруулах | 1 | 14,150.0 | 1 | 14,150.0 | | | | | | | | |
| 3 | | НӨАТ-ын үлдэгдэл 352,012.2 мянган төгрөгийн өр төлбөрийг улсын төсөвт төвлөрүүлээгүй байна. | Аудитын явцад нөхөн төлүүлж Залруулсан | 1 | 352,012.2 | 1 | 352,012.2 | | | | | | | | |
| 4 | | ААНОАТ-ын жилийн эцсийн тайлангийн өр төлбөр 295,435.7 мянган төгрөгийг хуулийн хугацаанд улсын төсөвт төвлөрүүлээгүй байна. | Аудитын явцад нөхөн төлүүлж Залруулсан | 1 | 295,435.7 | 1 | 295,435.7 | | | | | | | | |
| 5 | | Өмнөх оны аудитаар төрд учруулсан 19,551.2 мянган төгрөгийн хохирлыг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэхээр хүргүүлсэн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй байна. | Төлбөрийн акт тогтоох | 1 | 19,551.2 | | - | 1 | 19,551.2 | | | | | | |
| 6 | | Дуудлага худалдаа зохион байгуулах журмыг зөрчин сонирхол татахуйц дугаарын дуудлага худалдааны орлогоос зөөврийн компьютер, принтер, баримт үдэгч, камер, утасны аппарат зэрэг 31,641.6 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэж зориулалт бусаар зарцуулсан байна. | Албан шаардлага хүргүүлэх | 1 | 31,641.6 | | - | | | 1 | 31,641.6 | | | | |
| 7 | | Үйлдвэрийн газрын захирлын 2021 оны А/322 дугаар тушаалаар дархлаа дэмжих зорилгоор нийт 768 албан хаагчдад 367,250.0 мянган төгрөгийн буцалтгүй тусламжийг хавтгайруулан олгосон байна. | Албан шаардлага хүргүүлэх | 1 | - | | - | | | 1 | - | | | | |

| | | | | | | | | | | | | | | |
|------------|---|---|----|-----------|---|-----------|---|----------|---|----------|---|---|---|-----------|
| 8 | Драгон холдинг ХХК-тай байгуулсан 2016 оны ХХАГ16/020 дугаар гэрээт 2,888,463.0 мянган төгрөгийн 979.14 м.кв бүхий оффисын талбайн, мөн гэрээний 3.1.8-д заасан 3634.9 м.кв авто зогсоолын эзэмшлийн гэрчилгээг гэрээнд заасан хугацаанд гаргаж, үндсэн хөрөнгийн дансанд бүртгээгүй байна. | Албан шаардлага хүргүүлэх | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| 9 | Мөнгөн хөрөнгийг арилжааны банканд байршуулахдаа холбогдох журмыг мөрдөөгүй, эрсдэлийн үнэлгээ, хадгаламжийн дундаж хүүгийн түвшинг тооцолгүй нийт 4,000,000.0 мянган төгрөгийг ХХБ-нд 6.0%, Төрийн банканд 5.7%, Хаан банканд 5.5%-ийн хүүтэй 3 сарын хугацаатай байршуулсан байна. | Албан шаардлага хүргүүлэх | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| 10 | Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын харьяа 28 салбарын санхүүгийн тайланг бэлтгэж гаргах тухай Үндэсний аудитын газрын 2021 оны 297/А0170067 дугаар албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй байна. | Хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэх | 1 | - | | | | | | | 1 | - | | |
| 11 | Шатахуун зарцуулалтын нормыг захирал өдөрт 150км, дэд дарга 100км, 4 хэлтсийн дарга 85км-ээр тооцон баталсныг Засгийн газрын 184 дүгээр тогтоолоор баталсан нормтой харьцуулахад нийт 14,865.7 мянган төгрөгийн хэмнэж болох зардлыг илүү олгож, үр ашиггүй зарцуулсан байна. | Зөвлөмж өгөх | 1 | 14,865.7 | | | | | | | | | 1 | 14,865.7 |
| 12 | Урьдчилгаа дансны үлдэгдэлд өмнөх он болон тайлант хугацаанд хэрэгжиж дууссан зураг төслийн 4 ажлын нийт 91,014.4 мянган төгрөг бүртгэлтэй байна. | Зөвлөмж өгөх | 1 | 91,014.4 | | | | | | | | | 1 | 91,014.4 |
| 13 | НБББББ-т зааснаар борлуулсан бүтээгдэхүүний өртөгт салбар нэгжүүдийн нийт зардлыг тусган тайлагнаж байгаа нь байгууллагын нийт ашгийн үзүүлэлт, үйл ажиллагааны ашгийн тооцоог буруу илэрхийлж, удирдлагад стратегийн шийдвэр оновчтой гаргахад сөргөөр нөлөөлж байна. | Зөвлөмж өгөх | 1 | - | | | | | | | | | 1 | - |
| ДҮН | | | 13 | 931,152.6 | 4 | 774,079.7 | 1 | 19,551.2 | 4 | 31,641.6 | 1 | - | 3 | 105,880.1 |

| Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудал | | | | | | | | | | | | | | |
|--|---|--|---|-----------|------------------|----------|------------------|----------|-----------------|----------|-----------------|----------|----------|---------|
| 1 | Автотээврийн үндэсний төв | Худалдан авах ажиллагаа зохион байгуулж гэрээ байгуулалгүй 24,544.0 мянган төгрөгийг Андууд БГБХН-д шилжүүлж, шууд худалдан авалт хийж гүйцэтгэсэн байна. | Албан шаардлага хүргүүлэх | 1 | 24,544.0 | | | | | 1 | 24,544.0 | | | |
| 2 | АХГ-2022/26/НА-СТА-ТӨА | Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст нийт 4196 мэдээлэл байршуулахаас 42 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 2 мэдээлэл, 246,336.8 мянган төгрөгийн тушаал шийдвэрийг байршуулаагүй байна. | Хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэх | 1 | - | | | | | | 1 | - | | |
| ДҮН | | | | 2 | 24,544.0 | - | - | - | - | 1 | 24,544.0 | 1 | - | |
| АТҮТ-ИЙН ДҮН | | | | 15 | 955,696.6 | 4 | 774,079.7 | 1 | 19,551.2 | 5 | 56,185.6 | 2 | 3 | |
| Салбарын санхүүгийн тайлангийн асуудлаар | | | | | | | | | | | | | | |
| 1 | Баянзүрх дүүргийн Зорчигч тээврийн төв | Авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулах, баримтжуулах ажил хийгдээгүй байна. | Зөвлөмж өгөх | 1 | 574.1 | | | | | | | 1 | 574.1 | |
| 2 | | Тайлант оны элэгдлийн зардал дутуу тооцоолж тайлагнасан байна. | Зөвлөмж өгөх | 1 | 169.4 | | | | | | | | 1 | 169.4 |
| 3 | | Төлбөр тооцоог тооцооны дансаар дамжуулаагүй шууд зардалд бүртгэсэн. | Зөвлөмж өгөх | 1 | 2,970.0 | | | | | | | | 1 | 2,970.0 |
| 4 | СХД-ийн Зорчигч тээврийн төв | Драгон холдинг ХХК-тай байгуулсан 2,888.463.0 мянган төгрөгийн барилгын үл хөдлөх эдх хөрөнгийг баримт бичгийг байгууллагын нэр дээр шилжүүлж аваагүй байна. | Зөвлөмж өгөх | 1 | - | | | | | | | 1 | - | |
| 5 | СХД-ийн Техникийн хяналтын үзлэгийн төв | Мөнгөн гүйлгээний тайланд орлогыг зөрүүтэй буюу бүргэж тайлагнасан байна. | Зөвлөмж өгөх | 1 | 803.5 | | | | | | | 1 | 803.5 | |
| 6 | | Тайлант онд нэмэгдсэн өртгийн албан татварын өглөгийг дутуу бүртгэсэн байна. | Зөвлөмж өгөх | 1 | 414.6 | | | | | | | | 1 | 414.6 |
| 7 | Сэлэнгэ аймаг дахь Автотээврийн төв | Жолоочийн тооцооны хуудсыг батлагдсан маягтын дагуу бүртгээгүй байна. | Зөвлөмж өгөх | 1 | 6,649.0 | | | | | | | 1 | 6,649.0 | |
| 8 | | Байгууллагын ашиглаж байгаа программаас шалтгаалан бараа материалын дэлгэрэнгүй бүртгэлийг НӨАТ хасагдсан дүнгээр тооцоолж, улмаар бараа материалын тайлан болон бүртгэлийн дүнг зөрүүтэй тайлагнасан байна. | Зөвлөмж өгөх | 1 | - | | | | | | | | 1 | - |

“Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

| | | | | | | | | | | | | | | | |
|--|--|--|--------------|-----------|-----------------|----------|----------|----------|----------|----------|----------|----------|----------|-----------|-----------------|
| 9 | Орхон аймаг дахь Автотээврийн төв | Гэрээ хэлэлцээр хийлгүй Баян-Өндөр мөд эмнэлэг, Уран сархиа ХХК-нд 2,540.0 мянган төгрөгийг шилжүүлсэн байна. | Зөвлөмж өгөх | 1 | 2,540.0 | | | | | | | | | 1 | 2,540.0 |
| 10 | | Анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээг бүртгэлд тусгасан байна. | Зөвлөмж өгөх | 1 | 480.0 | | | | | | | | | 1 | 480.0 |
| 11 | Сүхбаатар аймаг дахь Автотээврийн төв | Үндсэн хөрөнгийн дансанд анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 56 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байна. | Зөвлөмж өгөх | 1 | - | | | | | | | | | 1 | - |
| 12 | | Байгууллагын барилгад дулааны тоолуур суурилуулсан боловч дулааны эрчим хүчний тогтоосон төлбөрийг мөрдөж ажиллаагүй байна. | Зөвлөмж өгөх | 1 | - | | | | | | | | | 1 | - |
| 13 | | Байгууллагын санхүүгийн тайланд бүртгэлгүй 5981 УНУ улсын дугаартай тээврийн хэрэгслийг ашиглаж байна. | Зөвлөмж өгөх | 1 | - | | | | | | | | | 1 | - |
| 14 | Дорнод аймаг дахь Автотээврийн төв | Санхүүгийн тайланд тусгасан 9,840.6 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. | Зөвлөмж өгөх | 1 | 9,840.6 | | | | | | | | | 1 | 9,840.6 |
| 15 | | Тайлант оны үйл ажиллагааны орлогын 426,230.6 мянган төгрөгийн төлөвлөгөөг 8.1 хувь буюу 34,729.4 мянган төгрөгөөр тасалсан байна. | Зөвлөмж өгөх | 1 | 34,729.4 | | | | | | | | | 1 | 34,729.4 |
| 16 | | Тайлант оны 9-р сарын жолоочийн тооцооны хуудсыг бүрэн хөтлөөгүй, гарын үсэг зурж баталгаажуулаагүй байна. | Зөвлөмж өгөх | 1 | 300.0 | | | | | | | | | 1 | 300.0 |
| 17 | Баянхонгор аймаг дахь Автотээврийн төв | Тус байгууллагын даргын 2021 оны 11 дүгээр тушаалаар томилогдсон тооллогын комисс тооллого хийж, нягтлан бодогч тооцоог бодсон боловч үр дүнг хэлэлцэж тушаалаар баталгаажуулаагүй байна. | Зөвлөмж өгөх | 1 | - | | | | | | | | | 1 | - |
| ДҮН | | | | 17 | 59,470.6 | - | - | - | - | - | - | - | - | 17 | 59,470.6 |
| Салбарын санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудал | | | | | | | | | | | | | | | |
| 1 | СХД-ийн Зорчигч тээврийн төв | Шилэн дансны цахим системд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 9 гүйлгээ буюу 36,912.4 мянган төгрөгийн гүйлгээ дутуу байршуулсан байна. | Зөвлөмж өгөх | 1 | - | | | | | | | | | 1 | - |
| 2 | Говьсүмбэр аймаг дахь Автотээврийн төв | Шилэн дансны 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг, 13,700.0 мянган төгрөгийн 2021 оны А/322 тушаалыг тус тус хугацаа хоцроож мэдээлсэн байна. | Зөвлөмж өгөх | 1 | - | | | | | | | | | 1 | - |

| | | | | | | | | | | | | | | | |
|------------------------------|--|---|--------------|-----------|--------------------|----------|------------------|----------|-----------------|----------|-----------------|----------|----------|-----------|------------------|
| 3 | Баянхонгор аймаг дахь Автотээврийн төв | Тус салбар нь 2021 онд 811,583.8 мянган төгрөгийн 151 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 780,971.9 мянган төгрөгийн 141 мэдээллийг хугацаандаа байршуулж, 30,611.9 мянган төгрөгийн 8 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. | Зөвлөмж өгөх | 1 | - | | | | | | | | | 1 | - |
| ДҮН | | | | 3 | - | - | - | - | - | - | - | - | - | 3 | - |
| САЛБАРЫН ДҮН | | | | 20 | 59,470.6 | - | - | - | - | - | - | - | - | 20 | 59,470.6 |
| АТҮТ ТӨҮГ-ЫН НИЙТ ДҮН | | | | 35 | 1,015,167.2 | 4 | 774,079.7 | 1 | 19,551.2 | 5 | 56,185.6 | 2 | - | 23 | 165,350.7 |



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 03 дугаар сарын 15 № 100/АО/160069
АХГ-2022/06/НА-СТА-ТВА
Төлбөр барагдуулах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны аудитаар төрд учруулсан 19,551,250.00 төгрөгийн хохирлыг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэхээр хүргүүлсэн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1 "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журмын 4.2.3-т заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Төрд учруулсан 19,551,250.00 /арван есөн сая таван зуун тавин нэгэн мянга хоёр зуун тавин/ төгрөгийн хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх арга хэмжээ авч ажиллан, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Төлбөрийн актын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын захирал Б.Гүрсоронзон, Хяналт-шинжилгээ, дотоод аудитын албаны дарга А.Дамбадаваа, Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга Р.Баасандорж нарт даалгав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

С.НАЦАГДОРЖ

Д.БОЛОР-ЭРДЭНЭ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Akt\2022\0315 Auditin 2 Газар-40.Docx

0001090253



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 455/А0160067
АХГ-2022/26/НА-СТА-ТВА

Улаанбаатар хот

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын харьяа 28 салбарын санхүүгийн тайланг бэлтгэж гаргах тухай Үндэсний аудитын газрын 2021 оны 297/А0170067 дугаар албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.11 "нэгтгэсэн санхүүгийн тайлан" гэж Компанийн тухай хуулийн 6.4-т заасан санхүүгийн тайланг", 4.1 "Аж ахуйн нэгж, байгууллага дараах бүртгэлийн стандартыг дагаж мөрдөнө", Компанийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 "Компанийн нийт гаргасан энгийн хувьцааны 20-50 хувийг өөр /толгой/ компани дангаараа буюу нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа тохиолдолд уг компанийг хараат компани гэнэ", 6.2 "Хараат компани нь бие даасан тайлан баланс гаргадаг хуулийн этгээд байна" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журмын 4.2.2-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

Зөрчил гаргасан буруутай албан тушаалтанд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын захирал Б.Гүрсоронзонд даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:


АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР

С.НАЦАГДОРЖ

АХЛАХ АУДИТОР

Д.БОЛОР-ЭРДЭНЭ



Монгол Улс Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо Бага тойруу-3, Вэсгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

0019128396

\\fd-10-10-20\Public\Монгол Албан Шаардлага\2022\0315 Auditin 2 Газар-142.Docx

0001081278



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 456/АД160069
АХТ-2022/26/НА-СТА-ТВА

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын захирлын 2021 оны А/322 дугаар тушаалаар дархлаа дэмжих зорилгоор нийт 768 албан хаагчдад 367,250,000.00 төгрөгийн буцалтгүй тусламжийг хавтгайруулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.3 "төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын захирал Б.Гүрсоронзон, Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга Р.Баасандорж нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *В. М. Ц. НАРАНЧИМЭГ*

АУДИТЫН МЕНЕЖЕР

С. А. Ц. НАЦАГДОРЖ
С.НАЦАГДОРЖ

АХЛАХ АУДИТОР

Д. БОЛОР-ЭРДЭНЭ
Д.БОЛОР-ЭРДЭНЭ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Бага тойруу 3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-261230

10.10.20\Bichig_Whereg\Alban Shaardlaga\2022\0315_Auditin 2 Gazar-139.Docx

001081272



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 457/АД/60069
АХГ-2022/26/НА-СТА-ТВА

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Мөнгөн хөрөнгийг арилжааны банканд байршуулахдаа холбогдох журмыг мөрдөөгүй, эрсдэлийн үнэлгээ, хадгаламжийн дундаж хүүгийн түвшинг тооцолгүй нийт 4,000,000,000.00 төгрөгийг ХХБ-д 6.0%, Төрийн банканд 5.7%, Хаан банканд 5.5%-ийн хүүтэй 3 сарын хугацаатай байршуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 "үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах", 67 дугаар зүйлийн 67.1 "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө харууцна", Сангийн сайд, Монголбанкны ерөнхийлөгчийн хамтарсан тушаалаар баталсан журмын холбогдох заалттай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Арилжааны банканд мөнгөн хөрөнгө байршуулах журам боловсруулж, мөрдөн ажиллах, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын захирал Б.Гүрсоронзон, Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга Р.Баасандорж нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁР ДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР

С.НАЦАГДОРЖ

АХЛАХ АУДИТОР

Д.БОЛОР-ЭРДЭНЭ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Сангийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

10.10.10.20-Bichig_Khereg:Alban Shaardloga\2022\0315 Auditin 2 Gasar-136.Docx

001081266



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 458/АУН60069
АХГ-2022/26/НА-СТА-ТБА

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Драгон холдинг ХХК-тай байгуулсан 2016 оны ХХАГ16/020 дугаар гэрээт 2,888,463,000.00 төгрөгийн 979.14 м.кв бүхий оффисын талбайн, мөн гэрээний 3.1.8-д заасан 3,634.9 м.кв авто зогсоолын эзэмшлийн гэрчилгээг гэрээнд заасан хугацаанд гаргаж, үндсэн хөрөнгийн дансанд бүртгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2 "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 67.4 "Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна", Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 55 дугаар тогтоолын 6.10.8 "үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгө худалдан авах болон акталж, устгах, худалдах, шилжүүлэх асуудлыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тавьж шийдвэрлүүлэх", Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолд заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Үл хөдлөх хөрөнгийн улсын бүртгэлийн гэрчилгээг гаргуулж, үндсэн хөрөнгөнд бүртгэх, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын захирал Б.Гүрсоронзон, Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга Р.Баасандорж нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХӨӨРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР

С.НАЦАГДОРЖ

АХЛАХ АУДИТОР

Д.БОЛОР-ЭРДЭНЭ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

9019120396

10.10.2022 10:30:00 reg/Alban Shaardlaga/2022/0315 Auditin 2 Gasar-138.Docx

0001081270



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 459/АДМ0069
АХГ-2022/26/НА-СТА-ТБА

Улаанбаатар хот

Г Сахилгын хариуцлага тооцуулах тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим хуудсанд нийт 4196 мэдээлэл байршуулахаас 42 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 2 мэдээлэл, 246,336,687.00 төгрөгийн тушаал шийдвэрийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4.5 "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.4.8 "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, тэр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөө, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр", Монгол Улсын Засгийн газрын 2016 оны "Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам" 29 дүгээр тогтоолын холбогдох заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журмын 4.2.2-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

Зөрчил гаргасан буруутай албан тушаалтанд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын захирал Б.Гүрсоронзонд даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР


АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

С.НАЦАГДОРЖ

Д.БОЛОР-ЭРДЭНЭ



Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тосруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230.

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban Shaardlaga\2022\0315 Auditin 2 Gazar-137.Docx

3001081268



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15

№ 460/А0160069

Улаанбаатар хот

АХТ-2022/06/НА-СТА-ТВА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд худалдан авах ажиллагаа зохион байгуулж, гэрээ байгуулалгүй 24,544,000.00 төгрөгийг Андууд БГБХН-д шилжүүлж, шууд худалдан авалт хийж гүйцэтгэсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 "Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ", 8.4 "Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно", 8.5 "Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно", 34 дүгээр зүйлийн 34.1 "Гэрээ шууд байгуулах аргыг зөвхөн дараахь нөхцөлд хэрэглэж болно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг мөрдөж ажиллах, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын захирал Б.Гүрсоронзон, Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга Р.Баасандорж нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Д.БОЛОР-ЭРДЭНЭ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 461/АД160067

Улаанбаатар хот

АХГ-2022/06/НА-СТА-ТВА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Дуудлага худалдаа зохион байгуулах журмыг зөрчин сонирхол татахуйц дугаарын дуудлага худалдааны орлогоос зөөврийн компьютер, принтер, баримт үдэгч, камер, утасны аппарат зэрэг 31,641,340.00 төгрөгийн хөрөнгө бэлтгэж, зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 21.2.2 "Хүүхдийн төлөө сангийн хөрөнгийн эх үүсвэр нь энэ хуулийн 6.1.1, 6.1.2-т зааснаас гадна дараах эх үүсвэрээс бүрдэнэ", 21.2.2.1 "автотээврийн хэрэгслийн сонирхол татахуйц улсын бүртгэлийн дугаар борлуулсны орлого", Автотээврийн тухай хуулийн 17.1.3 "Автотээврийн хэрэгслийн сонирхол татахуйц улсын бүртгэлийн дугаарыг үнэ хаялцуулах дуудлага худалдаагаар борлуулж болно", 7.1.4 "энэ хуулийн 17.1.3-т заасан орлогыг Хүүхдийн төлөө санд төвлөрүүлнэ", Монгол Улсын Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 1/1385 дугаар албан бичиг, Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын захирлын 2021 оны А/70 дугаар тушаалаар баталсан "Тээврийн хэрэгсэлийн улсын бүртгэлийн дугаарыг дуудлага худалдаагаар зохион байгуулах усирдамж"-ийн 2.13 "дуудлага худалдааны үйл ажиллагааны зардалд дараах зүйлс хамаарна. Үүнд: Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр зар мэдээ явуулсан зардал, программ хангамж хөгжүүлэлтийн зардал, дансны шимтгэл, сурталчилгааны зардал, бусад" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Дуудлага худалдааны үйл ажиллагааны зардлыг журмын дагуу санхүүжүүлж, үлдэгдэл орлогыг Хүүхдийн төлөө санд бүрэн төвлөрүүлэх, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын захирал Б.Гүрсоронзон, Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга Р.Баасандорж нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *Ц.Наранчимэг* Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР *С.Нацагдорж* С.НАЦАГДОРЖ
АХЛАХ АУДИТОР *Д.Болор-эрдэнэ* Д.БОЛОР-ЭРДЭНЭ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-261230



0001081774

